



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 01 дугаар сарын 24

Дугаар 01

Улаанбаатар хот

### I ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдаан 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14.00 цагт Төрийн ордон дахь “Сүхбаатар танхим”-д 99.7 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Их Монгол, Дүнжингарав худалдааны төвийн Авто замын уулзварт гарсан гал түймрийн талаар

*Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян*

2. Гал түймэр гарсантай холбогдуулан цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Нийслэлийн  
цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа О.Ганбат*

3. Гал түймэр гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын Тамгын газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал  
хариуцсан нэгдүгээр орлогч дарга П.Сайнзориг*

4. Гал түймрийн улмаас түлэгдсэн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй талаар

*Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн  
С.Чинзориг*

5. Бусад



## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

**Нэг. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энхбаяр, Барилга хот, байгуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Бямбацогт, Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн нарт:**

1.1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Их Монгол, Дүнжингарав хуралдааны төвийн Авто замын уулзарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны шөнө гарсан гал түймрийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд шаардлагатай хүн хүч, машин, техникийг дайчлан гаргаж, нийслэл, дүүргийн Онцгой комисст дэмжлэг үзүүлж ажиллах,

**Хоёр. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:**

2.1. Гал түймрийн улмаас амь насаа алдсан алба хаагчдын ар гэрт шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ахалж ажиллах,

**Гурав. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Чинзоригт:**

3.1. Гал түймэрт өртсөн айл өрх, түлэгдэж гэмтэн эмнэлэгт хэвтсэн иргэдэд сэтгэлзүйн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан ажиллах, ажлын явц, үр дүнг тухай бүр Улсын онцгой комисст танилцуулж ажиллах,

**Дөрөв. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатарт:**

4.1. Гал түймэрт өртөж, орон байр нь шатсан 60 гаруй айлын 100 гаруй иргэний байрыг засварлах, хохирлын хэмжээг бүрэн тогтоох хүртэл түрээсийн байранд түр хугацаанд байршуулахад шаардлагатай зардлын хэмжээг тогтоож, шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч дарга ахалж ажиллах,

4.2. Гал түймэрт өртөж, орон байр нь шатсан иргэдийг түр хугацаанд түрээсийн байранд байрлуулахад шаардлагатай хөрөнгө зардлын асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;



**Тав. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Сүхболдод:**

5.1. Нийгмийн хэв журам зөрчигдөх, иргэдийн эд хөрөнгийг хулгайлах, тонох гэх мэт гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллах, шаардлагатай хүн хүчийг нэмэгдүүлэх,

**Зургаа. Барилга, хот байгуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Ганбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Сүхболд, Стандарт, хэмжил зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Ууганбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар нарт:**

6.1. Шатахуун, хий зэрэг тэсэрч дэлбэрэх аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагаа нь хууль эрхзүйн болон стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх, батлагдсан стандарт, норм, дүрэм нь аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, үр дүнг Улсын онцгой комисс, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх,

**7. Барилга, хот байгуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар нарт:**

7.1. Гал түймэр, дэлбэрэлтэд өртсөн барилга байгууламжид үзлэг шалгалт хийж, цаашид ашиглалтын шаардлага хангах эсэхэд нэгдсэн дүгнэлт гаргаж, шийдвэрлэх, ажлын явц, үр дүнг тухай бүр Улсын онцгой комисст танилцуулж ажиллах,

**Найм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн Нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Э.Ганхүү нарт:**

8.1. Гал түймэрт өртсөн айл өрхүүдийн судалгааг нэн даруй гаргаж, иргэдийг нэн шаардлагатай цэвэр ус, хоол хүнс, дулаан хувцас, гэр, түр байраар хангах ажлыг шуурхай зохион байгуулж, дүүргийн Онцгой комисст дэмжлэг үзүүлэх, нэгдсэн зохицуулалт, удирдлагаар хангаж ажиллах,



Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ